



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/222

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн 1 иргэн, 1 аж ахуйн нэгжийн гаргасан өргөдлийн дагуу 0.2317га (2317м<sup>2</sup>) газрын газар эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар хугацааг сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын ...06...-ны өдрийн А/242 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын талбайн хэмжээ (м <sup>2</sup> )	Газрын байршил	Газрын зориулалт	Газар эзэмших хугацаа	Хүчингүй болгож буй шийдвэрийн огноо
1	Дамиран овгийн Уламбаяр Эрдэнэбат (ДЭ78091412)	6712015817	64	5-р баг Цагаан-Уул зах "Хатагтай" дэлгүүр	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	40	Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/226 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтын 8 дахь багана
2	"Шунхлай петролиум" ХХК (РД:5512972)	6712008691	2253	1-р баг Гандан-1 101 тоот	Шатахуун түгээх станц	40	Аймгийн Засаг даргын 2014 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн А/120 дугаар захирамжийн хавсралтын 14 дахь заалтын 7 дахь багана

Нийт талбайн хэмжээ-2317м<sup>2</sup>

-----000-----